



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Тогтмолын МӨНХСАЙХАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-02-55, Факс: 32-70-16
E-mail: munkhsaikhan@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025. 12. 31 № 444-03/15063
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай” анхдагч хуулийн төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд бид санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Т. МӨНХСАЙХАН

Д.ЭНХ-АМГАЛАН

М.МАНДХАЙ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б. БААСАНДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Тогтмолын МӨНХСАЙХАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-02-55, Факс: 32-70-16
E-mail: munkhsaikhan@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.11.25 № 410X-03/13443
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасны дагуу Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалтай холбоотой дараах хуулийн төсөл, холбогдох тайлан, судалгаануудыг хавсаргав. Үүнд:

1. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл;
2. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл;
3. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийн товч танилцуулга;
4. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоолол;
5. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөлд хийсэн үр нөлөөний үнэлгээний тайлан;
6. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааны ажлын тайлан
7. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөлтэй холбоотой дагалдах хуулийн төсөл.

Хавсралт..... хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Т. МӨНХСАЙХАН

000021



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.МӨНХСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.09.17 № ХТ/2533

танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255012607

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“19.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Улсын Их Хурлаас 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах буюу хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, үйлчилгээ, нэгдсэн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү зэрэг олон талт, цогц хамтын ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Тухайлбал, гэр бүл, нийгмийн болон цахим орчинд эрүүл мэнд, боловсролын салбар, хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгааллыг хэрхэн хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх үйл ажиллагааг уг хуульд нарийвчлан зааж хуульчилсан.


Гэтэл сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцаа нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа дээрх хуулийн зохицуулалттай давхардаж байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэж заасны дагуу тусгайлан анхдагч хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг сайтар нягтлах;

2.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.15 дахь хэсэгт суралцагчдад хийх тусгай үзлэг, шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, бусад үзлэг, шинжилгээний зардлыг суралцагчид ногдох хувьсах зардал болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагад олгож байгаа иргэнээр тооцон төсвөөс санхүүжүүлэхээр заажээ.


Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг Засгийн газраас тогтоохоор хуульчилсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүн”-д хуулийн төсөлд заасан дээрх зардлууд тусгагдаагүй байгааг анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн, хуулийн төслийн 19 дүгээр зүйлд заасан сургуулийн орчинд тавигдах шаардлагыг Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж, мөн хуулийн 39.2-т “энэ хуулийн 39.1-д заасан орчны норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсролын, эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж хуульчилсны дагуу стандарт, норм, нормативаар тогтоон хэрэгжүүлж байна.

3.Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д нийцүүлэн боловсруулах шаардлагатай.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



2024.11.24

СУРГУУЛИЙН ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Аливаа улс, үндэстний баялаг нь эрүүл иргэд байдаг. Эрүүл иргэдийг төлөвшүүлэхэд эрүүл амьдралын зөв дадал хэвшил чухал үүрэгтэй. Эрүүл насжилтаараа тэргүүлэгч орнуудын сайн туршлагаас үзвэл, иргэддээ эрүүл амьдралын зөв дадал хэвшил суулгахад сургуулийн орчин ихээхэн нөлөөтэй байна. Үүнтэй холбогдуулан, Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл байна.

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх эрхүүдийг дурджээ. Тэдгээрээс сурагчийн эрүүл мэндтэй холбоотой нэн чухал дараах эрхүүд байна. Үүнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрхүүд багтана. Мөн Үндсэн хуулиар төр нь иргэдийнхээ үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх, эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг хүлээдэг. Эдгээр үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх зорилгоор төрөөс урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулан ажиллаж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “АЛСЫН ХАРАА 2050”-ийн удиртгалд “Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болох” гэсэн алсын харааг тодорхойлсон бөгөөд амьдралын чанарыг хэмжих нэг гол хэмжүүр нь тухайн улсын иргэдийн эрүүл мэнд юм. Түүнчлэн Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм зорилгын нэг нь “эрүүл чийрэг, эрдэм

боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжих” юм. Үүний дагуу, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх зорилтыг дэвшүүлжээ.

Дээрх зорилгын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрүүл мэндийн зорилтод “Хүн амд эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хөтөлбөрт тусган эрүүл амьдралын зан үйлийг хэвшүүлнэ”, “Хүүхэд чөлөөт цагаараа эрүүл мэнд, бие бялдрын зөв дадал эзэмших орчин, нөхцөлийг орон сууцны гадна талбай, сургуулийн орчинд бүрдүүлнэ” гэж тусгасан байна.

Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогоор дэвшүүлсэн зорилгод хүрэх үр дүнтэй хувилбар нь ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоог ашиглан сурагчдыг бага ангиас нь эрүүл дадал хэвшилтэй болгох, тэдгээрийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, сургуулийн орчин дахь эрүүл ахуй, ариун цэвэр, ундны усны хэрэглээний зохистой байдлыг хангах, аливаа халдварт өвчин, осол, эндэгдэлд өртөхөөс сэргийлэх аюулгүй байдлын тогтолцоог бий болгох явдал юм.

1.2. Практик шаардлага

Статистикийн мэдээллийн сангийн 2024 оны тоон мэдээллээр Монгол Улсад нийт бүртгэлтэй 3,4 сая хүн оршин суудаг бөгөөд үүнээс 771,722 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцдаг нь нийт хүн амын 22 хувийг эзэлнэ. Энэ хувь хэмжээ нь хүн амын өсөлт болон төрөлттэй холбоотойгоор ойрын жилүүдэд нэмэгдэх төлөвтэй байна.

Ерөнхий боловсролын суралцагчийн эрүүл мэндийн тулгамдаж буй асуудал нь хүүхдийн эрүүл мэндийн асуудалтай салшгүй холбоотой. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яамнаас 2023 онд хийсэн “Боловсролын орчин дах хүүхдийн эрх, хамгааллын судалгаа”, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт”-ийг харуулсан 2023 оны эмхэтгэл, НҮБ-ын Хүүхдийн сангийн захиалгаар 2023 онд гүйцэтгэсэн “Хүүхдийн орчны эрүүл мэндийн

түргэвчилсэн тайлан”, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жил бүр гаргадаг “Монгол Улсын эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны 2023 оны үнэлгээ”, НҮБ-ын Хүүхдийн сан, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс 2024 онд хийж гүйцэтгэсэн “Дотуур байрны өнөөгийн байдал, хүчин чадлыг тодорхойлох судалгаа” зэрэг судалгаануудаас хүүхдийн эрүүл мэнд, зан үйл, сургуулийн орчны тулгамдсан асуудлуудыг тодорхой харж болно.

Тухайлбал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс нийтэлсэн “Эрүүл мэндийн үзүүлэлт-2023” эмхэтгэл тайланд дурдсанаар амбулаторид өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл тэргүүлэх шалтгаан болж байгаа бөгөөд ялангуяа 5-19 насны хүүхдийн өвчлөлд шүд цоорох, шүд ба дайврын эмгэг тэргүүлэх шалтгаан болж байна.

Монгол Улс нь Номхон далайн баруун бүсийн 37 орноос сүрьеэгийн халдвар өндөртэй орны тоонд багтдаг бөгөөд 2023 онд 2357 тохиолдолд бүртгэгдэж, өмнөх оноос 2 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. Шинээр бүртгэгдсэн тохиолдлын 2.6 хувийг 10-14 насны, 5.9 хувийг 15-19 насны хүүхдүүд эзэлж байгааг анхааралдаа авах шаардлагатай. Түүнчлэн, сургуулийн хүүхдийн дундах бахлуурын тархалт 2010 оны түвшингээс төдийлэн өөрчлөгдөөгүй, 6-11 насны хүүхдийн 7.8 хувь бахлууртай байна.

Монгол Улсын өсвөр насны охидын (15-19 насны) төрөлтийн түвшин 2023 оны ДЭМБ-ын статистикаар тухайн насны 1000 охидод харьцуулахад 26.9 байгаа нь дэлхийн дундаж (41.9)-аас доогуур байгаа хэдий ч Номхон далайн баруун бүсийн дундаж (16.9)-аас өндөр үзүүлэлттэй байна. Мөн онд 12197 үр хөндөлт бүртгэгдэж, үүний 5 хувийг 20-иос доош насны эмэгтэйчүүд эзэлж байна.

Дээрх судалгааны дүгнэлтүүд нь өсвөр насны болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын эрүүл мэндэд төрөөс анхаарах шаардлагатайг илтгэж байна. Үүнтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоогоор дамжуулан 6-17 насны суралцагчдын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, тооцоо судалгаанд үндэслэсэн хариу арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс нийтэлсэн “Эрүүл мэндийн үзүүлэлт-2023” эмхэтгэл тайланд дурдсанаар манай улсын хэмжээнд 2023 онд 210,763 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 11.6 хувиар өссөн ба үүний 28.5 хувийг 5-19 насны хүүхдүүд эзэлж байна. Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унаж гэмтэх тохиолдлын хувьд 10-14 насны хүүхдүүдийн 7.8 хувийг, 15-19 настай хүүхдүүдийн 3.7 хувь нь дээрх шалтгаанаар бэртжээ. Түүнчлэн тус тайлангийн зөвлөмжид “Монгол Улсын нийт хүн амын 30.9%-ийг 15 хүртэлх насны хүүхэд эзэлдэг хэдий ч хүүхдийн эрүүл мэндийг орчны аюултай хүчин зүйлсээс хамгаалахад чиглэсэн тусгайлсан бодлого байхгүй, харин эрүүл мэнд, байгаль орчин, боловсролын талаарх төрийн бодлогоор тодорхойлогдож байна” гэснийг анхаарах шаардлагатай.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, НҮБ-ийн хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2023 онд нийтэлсэн “Боловсролын орчин дах хүүхдийн эрх, хамгааллын судалгаа”-нд хөдөөгийн сургуулиудын 76.9 хувь, нийт сургуулиудын 78.9 хувьд нь гадаа тоглоомын болон биеийн тамирын талбайд осол гэмтлээс сэргийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй бөгөөд хотын сургуулийн 15.8 хувь, хөдөөгийн сургуулийн 9.4 хувьд гэрэлтүүлэг хангалтгүй гэсэн үр дүн гарчээ.

НҮБ-ийн Хүүхдийн сангийн захиалгаар 2024 онд хийгдсэн “Хүүхдийн орчны эрүүл мэндийн түргэвчилсэн үнэлгээний тайлан”-д дурдсанаар ерөнхий боловсролын сургуулийн 51 хувь нь авто замтай ойр, 79 хувь нь автомашины хурд сааруулагчгүй, 33 хувь нь стандартын шаардлага хангаагүй хашаатай, 77.2 хувь нь эдэлбэр газраа зориулалтаар нь ашигладаггүй, 73.2 хувь нь аюулгүй байдал хангасан биеийн тамирын талбайгүй, 13 хувь нь хүүхэд унаж, гэмтэх аюултай нүхтэй, 76.9 хувь нь гадна орчинд цахилгааны ил задгай утастай гэсэн дүгнэлтийг гаргажээ. Түүнчлэн тус тайланд дурдсанаар, сургууль, цэцэрлэгийн барилгад засвар хийсний дараагаар будаг, бусад материалаас ялгардаг формальдегид зөвлөмж хэмжээнээс 2.7-2.9 дахин, бензол 3.5 дахин, толуол болон п,м-ксилол тус бүр 3 дахин хэтэрсэн дүнтэй хэмжигдсэн байна. Мөн сургууль, цэцэрлэгийн барилгын хана, шалны будагт агуулагдах хар тугалга зөвлөмж хэмжээнээс 2-5, хром 2.3 дахин хэтэрсэн нь тус тус тогтоогджээ.

Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан манай улсын 2023 оны “Эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны үнэлгээ”-нд дурдсанаар манай улсад агаарын бохирдлоос үүдэлтэй зүрх, судасны өвчлөл болон цус харвалт нь нас баралтын шалтгаанд өндөр хувийг эзэлдэг. Үүнд Улаанбаатар хотод улирлын онцлогоос хамааран агаар дахь PM 2.5 хэмжээ байх ёстой хэмжээнээс 8 дахин их байдаг нь нэг сөрөг хүчин зүйл болж байна. Ялангуяа сургуулийн сурагчид хичээлдээ ирж, очих үедээ дээрх зөвлөмж хэмжээнээс 9 дахин, сургууль дээрээ 3.3 дахин хэтэрсэн PM 2.5 тоосонцорт өртөж байна.

Түүнчлэн, одоогоор мөрдөж буй хууль тогтоомжуудад сургуулийн барилга, байгууламж, сургалтын материал, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлын хяналт шалгалт дутмагаас осол гэмтэл гарсан тохиолдолд хэн хариуцах эсэх нь тодорхой бус байна.

Дээрхээс дүгнэвэл, сургуулийн орчинд тавигдах аюулгүй байдлын шаардлагыг тогтоосон холбогдох стандарт улс даяар бүрэн хангагдаж чадахгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь сургуулийн орчинд тавигдах аюулгүй байдлын холбогдох стандарт батлагдсан боловч, тэдгээрийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх, тайлагнах, хэрэгжүүлээгүй тохиолдолд авах хариуцлага зэргийг тодорхой болгох шаардлагатайг илтгэж байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу анхдагч хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн зорилго нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл амьдралын зөв дадлыг хэвшүүлэх болон сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах, гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1. Төрөөс суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих дунд хугацааны төлөвлөгөө батлах бөгөөд түүний хэрэгжилтийг жил бүр тайлагнах тогтолцоог бүрдүүлэх талаар тусгана.

2. Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, жил бүр хүний эрхэд суурилсан, холбогдох стандарт хангасан болон суралцагчийн хувийн мэдээлэл алдагдахаас сэргийлсэн орчинд үзлэг, шинжилгээ явуулах, түүний үр дүнд нийцсэн хариу арга хэмжээг тухайн сургуульд зохион байгуулах зохицуулалтыг тусгана.

3. Сургуулийн орчинд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, суралцагчдын эрүүл мэндийн боловсролыг дэмжихтэй холбогдох зохицуулалтыг тусгана.

4. Төрөөс сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах дунд хугацааны төлөвлөгөө батлах бөгөөд түүний хэрэгжилтийг жил бүр тайлагнах тогтолцоог бүрдүүлэх талаар тусгана.

5. Суралцагчдад сургуулийн орчны аюулгүй байдлын боловсрол олгох, гамшгаас урьдчилан сэргийлэх, даван гарах чадвар эзэмшүүлэх зохицуулалт тусгана.

6. Сургуулийн барилга, байгууламж, түүний орчинд тавигдах нэмэлт шаардлагыг тусгана.

7. Сургуулийн барилга, байгууламж, биеийн тамирын талбай, сургуулийн эзэмшил газарт аливаа аюулгүй байдалд холбогдох стандартыг бүрэн хангаагүйн улмаас бусдын эрүүл мэнд, хөрөнгө, амь насанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг тусгана.

8. Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох санхүүгийн олон талт эх үүсвэрийн талаарх зохицуулалт тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл боловсруулах замаар хүүхдийн эрүүл мэндийн эрх, аюулгүй орчинд сурч боловсрох эрхийг баталгаажуулах зохицуулалтыг шинээр бий болгох бөгөөд хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгах шаардлага байхгүй. Тиймээс хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөө байхгүй, эерэг нөлөөтэй.

Суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах дунд хугацааны төлөвлөгөө баталж, түүний хэрэгжилтийг жил бүр тайлагнах тогтолцоог бүрдүүлснээр суралцагч нарт эргэх холбоотой эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрдүүлэх боломжтой болно.

Суралцагчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг хүний эрхэд суурилсан, холбогдох стандарт хангасан болон суралцагчийн хувийн мэдээлэл алдагдахаас сэргийлсэн орчинд зохион байгуулснаар, үзлэг шинжилгээнээс үүсэх сөрөг үр дагавар арилж, суралцагчид багаасаа эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг шинжилгээнд орж хэвших, хүнд хэлбэрийн өвчлөлөөс эрт үед урьдчилан сэргийлэх боломжтой болно.

Суралцагчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулснаар, Монгол Улс даяар суралцагч хүүхдүүдийн эрүүл мэндийн мэдээлэл тогтмол цугларч, түүнд тохирсон хариу арга хэмжээг богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой болно.

Шинээр баригдах сургуулийн барилга болон тэдгээрийн орчинд тавигдах нэмэлт шаардлагыг тусгаснаар, цаашдаа суралцагчдыг орчны бохирдол, тэдгээрээс улбаатай өвчлөлөөс сэргийлэх боломжтой болно.

Сургуулийн барилга, байгууламж, биеийн тамирын талбай, сургуулийн эзэмшил газарт аливаа аюулгүй байдалд холбогдох стандартыг бүрэн хангаагүйн улмаас бусдын эрүүл мэнд, хөрөнгө, амь насанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгосноор, хариуцлага хүлээх этгээд болон сургуулийн зүгээс сургуулийн орчинд үүсэх аливаа хэлбэрийн осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэх явдалд онцгой анхаардаг болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, сурч боловсрох эрхийг баталгаажуулах ач холбогдолтой тул Монгол Улсын Үндсэн хуультай нийцнэ. Түүнчлэн, хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй бөгөөд суралцагч хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох зорилготой тул Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцнэ.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөлтэй хамт Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй
байдлын тухай хуулийн төсөл*

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 1995 онд санаачилсан “Эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийн тогтолцоог бий болгож, сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор тус хуулийн төслийг санаачлан, боловсрууллаа. Тус хуулийн төсөл нь 4 бүлэг 27 зүйлээс бүрдэнэ.

Энэ хуулийн төслөөр сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл аюулгүй, орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “АЛСЫН ХАРАА 2050”-ийн эрхэм зорилгын нэг нь “эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжих” юм. Тус зорилгын хүрээнд дэвшүүлсэн эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх зорилтод тус хуулийн төсөлд тусгагдсан дараах зарчмын шинжтэй зохицуулалтууд бүрэн нийцнэ. Үүнд:

1. Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн орчны эрүүл мэндийн тогтолцоог бий болгох;
2. Сургуулиар дамжуулан суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх;
3. Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн бодлогын хэрэгжилтийг жил бүр үнэлж, үр дүнг олон нийтэд мэдээлэх;
4. Суралцагчийн насанд тохирсон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулах арга хэмжээг нийт суралцагчдад хүртээмжтэй байдлаар зохион байгуулах;
5. Сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах;

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан манай улсын “Эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны үнэлгээ”-нд дурдсанаар, агаар дахь PM 2.5 хэмжээ байх ёстой хэмжээнээс 8 дахин их байна. Манай улсад агаарын бохирдлоос үүдэлтэй зүрх, судасны өвчлөл болон цус харвалт нь нас баралтын шалтгаанд өндөр хувийг эзэлдэг. Сургуулийн сурагчид хичээлдээ ирж, орчин үедээ дээрх зөвлөмж хэмжээнээс 9 дахин, сургууль дээрээ 3,3 дахин хэтэрсэн PM 2.5 тоосонцорт өртөж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, НҮБ-ын хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2023 онд нийтэлсэн “Боловсролын орчин дах хүүхдийн эрх, хамгааллын судалгаа – 2023”-т, хөдөөгийн сургуулиудын 76,9 хувь, нийт сургуулиудын 78,9 хувьд нь гадаа тоглоомын болон биеийн тамирын талбайд осол гэмтлээс сэргийлсэн тэмдэг,

тэмдэглэгээ хангалтгүй бөгөөд хотын сургуулийн 15,8 хувь, хөдөөгийн сургуулийн 9,4 хувьд гэрэлтүүлэг хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан.

НҮБ-ын Хүүхдийн сангаас 2024 онд боловсруулсан “Хүүхдийн орчны эрүүл мэндийн түргэвчилсэн үнэлгээний тайлан”-д дурдсанаар ерөнхий боловсролын сургуулийн 51 хувь нь авто замтай ойр, 79 хувь нь автомашины хурд сааруулагчгүй, 33 хувь нь стандартын шаардлага хангаагүй хашаатай, 77.2 хувь нь эдэлбэр газраа зориулалтаар нь ашигладаггүй, 73.2 хувь нь аюулгүй байдал хангасан биеийн тамирын талбайгүй, 13 хувь хүүхэд унаж, гэмтэх аюултай нүхтэй, 76.9 хувь нь гадна орчинд цахилгааны ил задгай утастай гэсэн судалгааны үр дүн гарчээ.

Дээрх судалгаануудад үндэслэн, сургуулийн орчинд суралцагч нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, жил бүр хүний эрхэд суурилсан, холбогдох стандарт хангасан болон суралцагчийн хувийн мэдээлэл алдагдахаас сэргийлсэн орчинд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хамрагдах, үр дүнд тулгуурлан хариу арга хэмжээ авах, сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн байх тул дээрх харилцааг хуулиар зохицуулж, заавал биелэгдэх шинжтэй, тогтвортой үйлчлэх зохицуулалтыг бий болгох замаар Монгол Улсад эрүүл мэндийг дэмжигч сургуулийн тогтолцоог бий болгож, цаашид суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг тогтвортой, нэг мөр хэрэгжүүлэхээр байна.

Хуулийн төслийг боловсруулахад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Эрүүл мэндийг дэмжигч сургууль” санаачилга (1995), Эрүүл мэндийг дэмжих Оттавагийн дүрэм (1986), Эрүүл мэндийг дэмжих олон улсын 4-р хурлаас баталсан Жакартагийн тунхаглал (1997), ДЭМБ-ын Шинжээчдийн хорооны Сургуулийн боловсрол болон эрүүл мэндийг дэмжих зөвлөмж (1995)-ийг судалснаас гадна, Япон Улсын Сургуулийн орчны эрүүл мэнд болон аюулгүй байдлын тухай хууль, Бүгд Найрамдах Солонгос Улсын Сургуулийн орчны эрүүл мэндийн тухай хууль, Финланд улсын эрүүл мэндийн дэмжигч сургуульд холбогдох эрх зүйн актыг харьцуулсны үндсэн дээр нийтлэг зарчмын шинжтэй зохицуулалтыг өөрийн улс орны онцлогт тулгуурлан хуулийн төсөлд тусгасан.

Одоогийн байдлаар, ази тивийн улс орнуудаас БНХАУ, Япон Улс, БНСУ, Лаос, Непал, Филиппин, Тайланд, Камбож, зэрэг улс орнууд эрүүл мэндийг дэмжигч сургуулийн тогтолцоог өөрийн улс орны онцлогт тулгуурлан бий болгож, эрх зүйн зохицуулалтыг боловсруулж, дагаж мөрдөж байна.

Дүгнэвэл, тус хуулийн төсөл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Шинжээчдийн хорооны “Сургуулиар дамжуулан эрүүл мэндийг дэмжих” тайланд онцгойлон тэмдэглэсэн *“Хүүхэд эрүүл байж, сургалт үр нөлөөтэй байна.”* гэх уриалгад тулгуурлаж, хуулийн төслийн зарчим, агуулга эрүүл мэндийг дэмжигч сургуулийн тогтолцоог бий болгож, нийт суралцагчдын эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд чиглэсэн болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Сургуулийн орчны эрүүл мэнд,
аюулгүй байдлын тухай хуулийн төсөл*

Аливаа улс, үндэстний баялаг нь эрүүл иргэд байдаг. Эрүүл иргэдийг төлөвшүүлэхэд эрүүл амьдралын зөв дадал хэвшил чухал үүрэгтэй. Монголын Улс 2050 онд эрүүл насжилтаар бүсийн хэмжээнд тэргүүлэх 10 орны нэг болох зорилт тавьсан байдаг. Энэ зорилтод хүрэхийн тулд, Монгол Улсын иргэдийн дундаж эрүүл насжилт 6 насаар ахиулах шаардлагатай. Эрүүл насжилтаараа тэргүүлэгч орнуудын сайн туршлагаас үзвэл, иргэддээ эрүүл амьдралын зөв дадал хэвшил суулгахад сургуулийн орчин ихээхэн нөлөөтэй байна. Үүнтэй холбогдуулан, сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл аюулгүй, орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг төгөлдөршүүлэх шаардлага үүсжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх эрхүүдийг дурджээ. Тэдгээрээс сургуулийн орчны эрүүл мэндтэй холбоотой нэн чухал дараах эрхүүд байна. Үүнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрхүүд багтана. Төр нь иргэдийнхээ үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх, эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг хүлээдэг. Эдгээр үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх зорилгоор төрөөс урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулан ажиллаж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “АЛСЫН ХАРАА 2050”-ийн удиртгалд “Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно” гэсэн бөгөөд амьдралын чанарыг хэмжих нэг гол хэмжүүр нь тухайн улсын иргэдийн эрүүл мэнд юм. Түүнчлэн Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм зорилгын нэг нь “эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжих” юм. Үүний дагуу, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх зорилтыг дэвшүүлжээ.

Үүний хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрүүл мэндийн зорилтод “Хүн амд эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хөтөлбөрт тусган эрүүл амьдралын зан үйлийг хэвшүүлнэ”, “Хүүхэд чөлөөт цагаараа эрүүл мэнд, бие бялдрын зөв дадал эзэмших орчин, нөхцөлийг орон сууцны гадна талбай, сургуулийн орчинд бүрдүүлнэ” гэжээ.

Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогоор дэвшүүлсэн зорилгод хүрэх үр дүнтэй хувилбар нь ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоог ашиглан суралцагчдыг бага ангиас нь эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, тэдгээрийн эрүүл мэндийг хамгаалах, сургуулийн орчин дахь аливаа осол, эндэгдэлд өртөхөөс сэргийлэх аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

2024 оны Статистикийн мэдээллийн сангийн мэдээллээр Монгол Улсад нийт 3,4 сая хүн оршин суудаг бүртгэлтэй, үүнээс 771,722 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцдаг нь нийт хүн амын 22 хувийг эзэлнэ. Мөн бага дунд боловсролын 61016 ажилтан, багш, албан хаагч, ажиллаж байна.

Энэ хувь хэмжээ нь хүн амын өсөлт болон төрөлттэй холбоотойгоор ойрын жилүүдэд нэмэгдэх төлөвтэй байна. Ерөнхий боловсролын суралцагчийн эрүүл мэндийн тулгамдаж буй асуудлыг тодорхойлоход хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг тодорхойлохтой холбогдон хийгдсэн судалгаануудаас харж болно.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс нийтэлсэн “Эрүүл мэндийн үзүүлэлт-2023” эмхэтгэл тайланд дурдсанаар амбулаторид өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл тэргүүлэх шалтгаан болж байгаа бөгөөд ялангуяа 5-19 насны хүүхдийн өвчлөлд шүд цоорох, шүд ба дайврын эмгэг тэргүүлэх шалтгаан болж байна.

Монгол Улс нь Номхон далайн баруун бүсийн 37 орноос сүрьеэгийн халдвар өндөртэй орны тоонд багтдаг бөгөөд 2023 онд 2357 тохиолдолд бүртгэгдэж, өмнөх оноос 2 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. Шинээр бүртгэгдсэн тохиолдлын 2,6 хувийг 10-14 насны, 5,9 хувийг 15-19 насны хүүхдүүд эзэлж байгааг анхааралдаа авах шаардлагатай. Түүнчлэн, сургуулийн хүүхдийн дундах бахлуурын тархалт 2010 оны түвшингээс төдийлэн өөрчлөгдөөгүй, 6-11 насны хүүхдийн 7.8 хувь бахлууртай байна.

Монгол Улсын өсвөр насны охидын (15-19 насны) төрөлтийн түвшин 2023 оны ДЭМБ-ын статистикаар тухайн насны 1000 охидод харьцуулахад 26,9 байгаа нь дэлхийн дундаж (41.9)-аас доогуур байгаа хэдий ч Номхон далайн баруун бүсийн дундаж (16.9)-аас өндөр (27,9) үзүүлэлттэй байна. Мөн онд 12197 үр хөндөлт бүртгэгдэж, үүний 5 хувийг 20-иос доош насны эмэгтэйчүүд эзэлж байна.

Дээрх статистик мэдээллүүд өсвөр насны болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын эрүүл мэндэд төрөөс анхаарах шаардлагатайг илтгэж байна. Үүнтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоогоор дамжуулан 6-17 насны суралцагчдын эрүүл мэндэд хамгаалах, дэмжих, тооцоо судалгаанд үндэслэсэн хариу арга хэмжээ авах эрх зүйн үндэслэл бий болгох шаардлагатай байна.

Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс нийтэлсэн “Эрүүл мэндийн үзүүлэлт-2023” эмхэтгэл тайланд дурдсанаар манай улсын хэмжээнд 2023 онд 210,763 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 11.6 хувиар өссөн ба үүний 28.5 хувийг 5-19 насны хүүхдүүд эзэлж байна. Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унаж гэмтэх тохиолдлын хувьд, 10-14 насны хүүхдүүдийг 7,8 хувийг, 15-19 настай хүүхдүүдийн 3,7 хувь нь дээрх шалтгаанаар бэртжээ. Түүнчлэн тус тайлангийн зөвлөмжид зааснаар “Монгол Улсын нийт хүн амын 30.9%-ийг 15 хүртэлх насны хүүхэд эзэлдэг хэдий ч хүүхдийн эрүүл мэндийг орчны аюултай хүчин зүйлсээс хамгаалахад чиглэсэн тусгайлсан бодлого байхгүй, харин эрүүл мэнд, байгаль орчин, боловсролын талаарх төрийн бодлогоор тодорхойлогдож байна гэсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, НҮБ-ийн хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2023 онд нийтэлсэн “Боловсролын орчин дах хүүхдийн эрх, хамгааллын судалгаа – 2023”-т, хөдөөгийн сургуулиудын 76,9 хувь, нийт сургуулиудын 78,9 хувьд нь гадаа тоглоомын болон биеийн тамирын талбайд осол гэмтлээс сэргийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй бөгөөд хотын сургуулийн 15,8 хувь, хөдөөгийн сургуулийн 9,4 хувьд гэрэлтүүлэг хангалтгүй гэсэн үр дүн гарчээ.

НҮБ-ийн Хүүхдийн сангаас 2024 онд боловсруулсан “Хүүхдийн орчны эрүүл мэндийн түргэвчилсэн үнэлгээний тайлан”-д дурдсанаар ерөнхий боловсролын сургуулийн 51 хувь нь авто замтай ойр, 79 хувь нь автомашины хурд сааруулагчгүй, 33 хувь нь стандартын шаардлага хангаагүй хашаатай, 77.2 хувь нь эдэлбэр газраа зориулалтаар нь ашигладаггүй, 73.2 хувь нь аюулгүй байдал хангасан биеийн тамирын талбайгүй, 13 хувь хүүхэд унаж, гэмтэх аюултай нүхтэй, 76.9 хувь нь гадна орчинд цахилгааны ил задгай утастай гэсэн судалгаа гаргажээ. Түүнчлэн тус тайланд дурдсанаар, сургууль, цэцэрлэгийн барилгад засвар хийсний дараагаар будаг, бусад материалаас ялгардаг формальдегид зөвлөмж хэмжээнээс 2.7-2.9 дахин, бензол 3.5 дахин хэтэрсэн дүнтэй хэмжигджээ. Мөн сургууль, цэцэрлэгийн барилгын хана, шалны будагт агуулагдах хар тугалга зөвлөмж хэмжээнээс 2-5, хром 2.3 дахин хэтэрсэн нь тус тус тогтоогдсон байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан манай улсын 2023 оны “Эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны үнэлгээ”-нд дурдсанаар, агаар дахь PM 2.5 хэмжээ байх ёстой хэмжээнээс 8 дахин их байна. Манай улсад агаарын бохирдлоос үүдэлтэй зүрх, судасны өвчлөл болон цус харвалт нь нас баралтын шалтгаанд өндөр хувийг эзэлдэг. Сургуулийн сурагчид хичээлдээ ирж, орчин үедээ дээрх зөвлөмж хэмжээнээс 9 дахин, сургууль дээрээ 3,3 дахин хэтэрсэн PM 2.5 тоосонцорт өртөж байна.

Түүнчлэн, одоогоор мөрдөж буй хууль тогтоомжуудад сургуулийн барилга, байгууламж, сургалтын материал, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлын хяналт шалгалт дутмагаас осол гэмтэл гарсан тохиолдолд хэн хариуцах эсэх нь тодорхой бус байна.

Дээрхээс үзвэл, сургуулийн орчинд тавигдах аюулгүй байдалтай холбогдуулан шаардлагатай холбогдох стандартууд батлагдсан байдаг боловч улс даяар бүрэн хэрэгжихгүй, зохицуулалт хангалтгүй байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, сургуулийн орчинд тавигдах аюулгүй байдалтай холбогдуулан шаардлагатай холбогдох стандарт батлагдсан боловч, тэдгээрийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх, тайлагнах, хэрэгжүүлээгүй тохиолдолд авах хариуцлага зэргийг тодорхой болгох шаардлагатайг илтгэж байна.

Тийнхүү, дээрх шаардлагыг үндэслэн асуудлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг анхдагч хуулийн төслийн хэлбэрээр боловсрууллаа.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл нь 4 бүлэг 27 зүйлээс бүрдэнэ.

1.Тус хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт, тус хуулийн зорилго, хууль тогтоомжийн актын бүрдэл, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, зарчмыг тусгалаа.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн зорилго нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл аюулгүй, орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Хүнсний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэх бөгөөд Монгол Улсын нэгдэн олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

Тус хуулийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

- ялгаварлан гадуурхахгүй байх;
- тэгш хандах;
- хүмүүнлэг, энэрэнгүй хандах;
- суралцагчийн хувийн болон эмзэг мэдээллийн нууцлалыг чанд хадгалах;
- суралцагчийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих;
- эрүүл аюулгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх.

2.Тус хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт, сургуулийн эрүүл мэндийн тогтолцоонд холбогдох дараах зохицуулалтуудыг тусгалаа.

Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн баримтлах нийтлэг бодлогыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн боловсруулж, батлах бөгөөд энэхүү нийтлэг бодлогод нийцүүлэн сургууль бүр өөрийн эрүүл мэндийн бодлогыг баталж, хэрэгжүүлэх зохицуулалт тусгасан. Энэ нь бүх сургууль нэгдсэн чиглэлтэй, тогтвортой эрүүл мэндийн бодлого хэрэгжүүлж, “эрүүл мэндийг дэмжигч сургууль” болох, суралцагч, багш, ажилчдын эрүүл орчинд суралцах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал эрх зүйн орчин болно.

Мөн төрөөс суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих дунд хугацааны төлөвлөгөө батлах бөгөөд түүний хэрэгжилтийг жил бүр тайлагнах тогтолцоог бүрдүүлэх талаар тусгалаа. Ингэснээр, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах эргэх холбоотой эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, бодлогоор хангах боломж бүрдүүлэхээс гадна тайлагналын системээр дамжуулан олон нийтийн хяналт, ил тод байдлыг бий болгоно.

Сургуулийн орчинд осол, гэнэтийн өвчлөлд шуурхай хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай эрүүл мэндийн тоног, төхөөрөмжөөр тохижуулсан эрүүл мэндийн өрөөг бий болгох, ашиглалтын бэлэн байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгасан. Ингэснээр, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах анхны хариу арга хэмжээг сургуулийн хүрээнд цаг алдалгүй авах, амь нас, эрүүл мэндийг аврах, хүндрэлээс сэргийлэх боломжийг бүрдүүлнэ.

Сургуулийн орчинд суралцагч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, жил бүр хүний эрхэд суурилсан, холбогдох стандарт хангасан болон суралцагчийн хувийн мэдээлэл алдагдахаас сэргийлсэн орчинд үзлэг, шинжилгээ явуулах, түүний үр дүнд нийцсэн хариу арга хэмжээг тухайн сургууль, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон тухайн шатны Засаг даргатай хамтран зохион байгуулах зохицуулалтыг тусгалаа. Ингэснээр, үзлэг, шинжилгээнээс үүсэх сөрөг үр

дагавар арилж, суралцагчид багаасаа эрт илрүүлэгд орж хэвших, хүнд хэлбэрийн өвчлөлөөс эрт үед урьдчилан сэргийлэх боломжтой болно. Түүнчлэн суралцагчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулснаар, Монгол Улс даяар суралцагч хүүхдүүдийн эрүүл мэндийн дата мэдээлэл тогтмол цугларч, түүнд тохирсон хариу арга хэмжээг богино хугацаанд авах боломжийг нэмэгдүүлнэ. Мөн суралцагчийн холбогдох насны өвчлөлийн онцлогийг тусгасан шинжлэх ухааны үндэслэлтэй үзлэг, шинжилгээний ангиллыг бий болгох замаар шаардлагагүй ажлын ачаалал, улсын төсвийн хэт дарамт үүсгэхээс сэргийлсэн.

Дээрх үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулах болсонтой холбоотойгоор уг зохион байгуулагч нь суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн санд үзлэг, шинжилгээний үр дүнг тусгах, суралцагчдын эрүүл мэндийн тайланг нэгтгэн боловсруулж, тайлагнах, уг тайланд үндэслэн сургуулийн захирал нь сум, дүүргийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран сургуулийн хэмжээнд суралцагчдын эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, энэ үйл ажиллагааг жил бүр аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар тайлагнах зохицуулалтыг тусгасан. Мөн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь бүс нутгийн суралцагчдын эрүүл мэндийн тайланг боловсруулж, эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд эдгээр төрийн захиргааны төв байгууллагууд нь ирүүлсэн тайланг нэгтгэж суралцагчдын эрүүл мэндийн улсын хэмжээний үзүүлэлтийг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд тайлагнахаар зохицуулалт тусгасан. Үүний үр дүнд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний үр дүнг ашиглан нотолгоонд суурилсан төлөвлөлт хийх, эрүүл мэндийн эрсдэлд өртөх магадлалтай бүлгийг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой төлөвлөх, улмаар хүүхдийн эрүүл мэндийн хяналтыг улсын хэмжээнд системтэйгээр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Түүнээс гадна үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр өвчтэй эсвэл өвчлөх эрсдэлтэй гэж оношлогдсон суралцагчийг өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгосон бөгөөд үүний үр дүнд суралцагч нэг бүрийн амь нас, эрүүл мэнд хамгаалагдах эрх зүйн үндэс бий болно.

Мөн түүнчлэн тус хуулийн зохицуулалтаар сургуулийн орчинд тархах эрсдэл бүхий халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ариутгал хийх, сэтгэл зүйн зөвлөгөөнд холбогдох зохицуулалтыг тусгалаа. Ингэснээр, сурагчдын бие махбод болон сэтгэл зүйн эрүүл мэндийг цогцоор нь дэмжих, эрт шатанд тусламж үзүүлэх, сургуулийн орчны сөрөг нөлөөллийг системтэй бууруулах боломжийг бүрдүүлнэ. Мөн суралцагчдад эрүүл өсөлт хөгжил, халдварт өвчин, халдварт бус өвчин, донтолт, осол гэмтэл, хүчирхийлэл, сэтгэц, бэлгийн болон нөхөн үржихүй, эрүүл ахуйн гар угаах, шүд угаах, хог хаягдлын менежмент, ариун цэврийн өрөөг зохистой ашиглах гэх мэт амьдрах ухааны ур чадваруудыг багтаасан эрүүл мэндийн боловсролын зохицуулалтыг тусгалаа. Энэ нь амьдрах ухааны суурь чадваруудыг төлөвшүүлэх зорилготой урьдчилан сэргийлэх боловсролын агуулгыг багтааж, сургуулийн насны хүүхдэд оновчтой, үе шаттай олгох тогтолцоог бий болгоно.

3.Тус хуулийн төслийн гуравдугаар бүлэгт, сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах, аливаа осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн стандартын хэрэгжилтийг хангах, түүнээс учирсан нөхөн төлбөр олгохтой холбогдох дараахь агуулга бүхий зохицуулалтуудыг тусгалаа.

Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь 4 жил тутамд сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж, олон нийтэд тайлагнахаар зохицуулсан бол, энэхүү төлөвлөгөөнд нийцүүлэн Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон тухайн шатны Засаг дарга сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх орон нутгийн төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжүүлэх, тайлагнахаар, харин сургуулийн захирлын хувьд тухайн сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургуулийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, баталж, хэрэгжүүлэхээр зохицуулсан. Энэ нь үндэсний түвшнээс орон нутаг, сургууль хүртэлх шатлал бүхий төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, сургуулийн орчны аюулгүй байдлыг эрсдэлд суурилан үнэлэх, сайжруулах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөлийг хангах эрх зүйн үндэс болно.

Мөн энэ бүлэгт сургууль нь суралцагчдад аюулт үзэгдэл, гамшгийн үед хүний амь нас аврах, гамшгийн нөхцөл байдлыг даван гарах анхан шатны чадварыг эзэмшүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах, сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлийн улмаас хохирсон суралцагч, тэдгээрийн гэр бүлийнхэнд сэтгэл зүйн тогтвортой байдал болон нийгэмд дасан зохицуулах зорилгоор зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйн эмчилгээ хийх зэрэг шаардлагатай дэмжлэгийг үзүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг тусгасан. Ингэснээр суралцагчийн амь нас, эрүүл мэндэд учрах эрсдэлийг бууруулах, осол гэмтлийн дараах нөхөн сэргээх үйлчилгээг системтэй, шаталсан байдлаар зохион байгуулах нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн сургуулийн орчинд тавигдах нэмэлт шаардлагыг тусгасан бөгөөд, цаашдаа суралцагчдыг орчны бохирдол, тэдгээрээс улбаатай өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

Сургуулийн барилга, байгууламж, биеийн тамирын талбай, сургуулийн эзэмшил газар дээрх аливаа аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох стандартыг бүрэн хангаагүйн улмаас бусдын эрүүл мэнд, хөрөнгө, амь насанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээх этгээдийг тодорхой болголоо. Ингэснээр, сургуулийн эзэмшил газар дээрх хохирсон иргэдийн хохирлыг нэн тэргүүнд нөхөн төлүүлэх боломжтой болно. Түүнчлэн, хариуцлага хүлээх этгээд тодорхой болсноор тухайн этгээд болон сургуулийн зүгээс сургуулийн орчинд үүсэх аливаа хэлбэрийн осол, гэмтэл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх явдалд онцгой анхаардаг болно.

4.Тус хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт, тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох санхүүгийн олон талт эх үүсвэрийг ашиглаж болох эрх зүйн үндэслэлийг тусгалаа.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, сурч боловсрох эрхийг баталгаажуулах ач холбогдолтой тул Монгол Улсын Үндсэн хуультай нийцнэ. Түүнчлэн, хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй бөгөөд суралцагч хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох зорилготой тул Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СУРГУУЛИЙН ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл аюулгүй, орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын хууль тогтоомж

2.1.Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Хүнсний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хууль үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“эрүүл мэндийн баг” гэж сургуулийн захирал, эрүүл мэндийн арга зүйч багш, сэтгэл зүйч, хоол зүйч, нийгмийн ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөлөл, суралцагчийн төлөөллөөс бүрдсэн бүрэлдэхүүнийг;

4.1.2.“эрүүл мэндийг хамгаалах” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасныг;

4.1.3.“эрүүл мэндийг дэмжих” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.19-т заасныг;

4.1.4.“эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.3-т заасныг;

4.1.5.“хариу арга хэмжээ” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3.1.8-д заасныг;

4.1.6.“сургуулийн орчин” гэж Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасныг;

4.1.7.“суралцагчийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ” гэж бие бялдрын хөгжил, сэтгэцийн эрүүл мэндийн байдал, амьдралын зан үйлийн эрсдэлийг үнэлэх болон халдварт болон халдварт бус өвчний эмнэл зүйн үзлэгийг;

4.1.8.“хяналт, тандалтын цахим бүртгэлийн сан” гэж суралцагчийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ, хяналт, дархлаажуулалт, халдварт өвчний тохиолдол гэх мэт суралцагчийн эрүүл мэндтэй холбогдох мэдээллийг бүртгэх цахим санг;

4.1.9.“суралцагчийг тодорхойлох боломжгүй болгох” гэж Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т заасныг;

4.1.10.“эрүүл мэндийг дэмжигч сургууль” гэж суралцагч, сургуулийн багш, ажилтны суралцах, ажиллах эрүүл аюулгүй орчныг тасралтгүй бүрдүүлдэг, суралцагчийн бие, сэтгэл, нийгмийн эрүүл мэндийг бүх талаас нь дэмжих орчин бүхий сургуулийг.

5 дугаар зүйл.Суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зарчим

5.1.Суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахтай холбогдох энэ хуульд заасан үйл ажиллагааг зохион байгуулахад дараах зарчмыг баримтална:

5.1.1.ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.2.тэгш хандах;

5.1.3.хүмүүнлэг, энэрэнгүй хандах;

5.1.4.суралцагчийн хувийн болон эмзэг мэдээллийн нууцлалыг чанд хадгалах;

5.1.5.суралцагчийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих;

5.1.6.эрүүл аюулгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх.

5.2.Энэ хуульд заасан зохицуулалтыг нэг мөр ойлгоход эргэлзээ үүсвэл, дээрх зарчимд нийцүүлэн ойлгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ СУРГУУЛИЙН ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦОО

6 дугаар зүйл. Сургуулийн орчны эрүүл мэндийн бодлого

6.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн баримтлах нийтлэг бодлогыг боловсруулж, батална. Тус бодлогод дараах агуулгыг заавал тусгана:

6.1.1.сургуулийн орчинд эрүүл мэндийг дэмжих, хамгаалах зорилт, чиглэлүүд;

6.1.2.сургуулийн эрүүл орчныг бүрдүүлэхэд авах арга хэмжээ, үйл ажиллагаа;

6.1.3.суралцагч, багш, ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндийн хамгаалах шийдэл;

6.1.4.хоол тэжээл ба хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ;

6.1.5.эрүүл мэндийн тухай мэдлэг, чадварыг олгох боловсрол.

6.2.Эрүүл мэндийг дэмжигч сургууль нь сургуулийн эрүүл мэндийн бодлоготой байх бөгөөд сургуулийн эрүүл мэндийн бодлогыг энэ хуулийн 6.1-д заасан бодлогод нийцүүлэн сургуулийн эрүүл мэндийн баг боловсруулж, батална.

6.3.Сургууль нь 9 гишүүн бүхий эрүүл мэндийн багтай байх бөгөөд тус багт сургуулийн захирал, эрүүл мэндийн арга зүйч багш, сэтгэл зүйч, хоол зүйч, нийгмийн ажилтан тус бүр нэг, суралцагч болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөлөл тус бүр хоёр байхаар бүрдүүлнэ. Бага болон тусгай сургуулийн хувьд суралцагчийн төлөөллийг оруулахгүй.

6.4.Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн бодлогыг хэрэгжүүлэхэд сургуулийн захирал дараах хэлбэрээр оролцоно:

6.4.1.эрүүл сургуулийг дэмжигч сургуулийн бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

6.4.2.эрүүл мэнд, эрүүл орчныг дэмжих бодлогын хэрэгжилтийг жил бүр үнэлж, дүнг олон нийтэд мэдээлэх.

6.5.Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн бодлогыг хэрэгжүүлэхэд сургуулийн багш дараах хэлбэрээр оролцоно.

6.5.1.суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл ахуй, аюулгүй байдлыг сахиулах, эрүүл амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

6.5.2.эрүүл мэндийн боловсролын сургалт, арга зүйн мэдлэгийг тасралтгүй хөгжүүлэх;

6.5.3.сургуулийн дотоод журам, өдөр тутмын үйл ажиллагаанд эрүүл орчин, аюулгүй байдлыг хангахад хяналт тавих.

6.6.Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн бодлогыг хэрэгжүүлэхэд суралцагч дараах хэлбэрээр оролцоно:

6.6.1.өөрийн эрүүл мэндийг хамгаалах, зөв амьдралын хэв маяг төлөвшүүлэхэд идэвхтэй оролцох;

6.6.2.эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчныг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.

6.7.Сурагчийн зөвлөлийн дэргэд эрүүл мэндийг дэмжих дэд зөвлөл ажиллаж болно.

6.8.Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн бодлогыг хэрэгжүүлэхэд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах хэлбэрээр оролцоно.

6.8.1.хүүхдийн эрүүл мэнд, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, зөв дадал хэвшүүлэхэд гэр бүлийн түвшинд хариуцлагатай оролцох;

6.8.2.эцэг эхийн зөвлөл сургуулийн эрүүл орчны бодлого, төлөвлөгөөг боловсруулах,хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.

6.9.Сургуулиас эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан эрүүл мэндийн сургалт, мэдээллийг улирал бүр зохион байгуулна.

6.10.Сургуулийн захирал, багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоог сургуулийн чанарын үнэлгээний үзүүлэлтэд тусгана.

7 дугаар зүйл.Суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих төлөвлөгөө

7.1.Суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны 4 жилийн төлөвлөгөөг эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.

7.2.Боловсролын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд нь суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг дараагийн хичээлийн жил эхлэхээс өмнө жил бүр цахим хэлбэрээр байршуулж, олон нийт болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлд тайлагнана.

7.3.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл нь энэ хуулийн 7.2-т заасан тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.4.Суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнахад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтан нэн даруй гаргаж өгөх үүрэгтэй.

7.5.Эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд нь энэ хуулийн 7.1-д заасан төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнахад шаардлагатай санхүүгийн төлөвлөлтийг жил бүр хийж, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

8 дугаар зүйл.Суралцагчийн эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах

8.1.Сургууль нь эрүүл мэндийн байгууллагатай хамтран суралцагчийн эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурласан анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

8.2.Сургууль нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай эрүүл мэндийн тоног, төхөөрөмжөөр тохижуулсан эрүүл мэндийн өрөөтэй байна.

8.3.Сургуулийн захирал нь эрүүл мэнд өрөөний стандартын шаардлагыг хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмжийн ашиглалтад тогтмол хяналт тавьж, хэвийн ажиллагааг хангах үүрэгтэй.

8.4.Сургууль нь сургалтын болон яаралтай үед ашиглах эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний багц болон зөөврийн автомат зүрхний сэдээгчтэй байна.

9 дүгээр зүйл.Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ

9.1.Сургуулийн захирал нь суралцагчийн ээлжит эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг хичээлийн шинэ жил эхэлснээс хойш 3 сарын дотор сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон тухайн шатны Засаг даргатай хамтран жил бүр зохион байгуулна.

9.2.Эмнэлгийн байгууллагад хийгдэхээс бусад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг эрүүл ахуйн шаардлага хангасан, суралцагчдын эмзэг мэдээлэл задрахаас хангалттай сэргийлсэн сургуулийн орчинд хийж болох бөгөөд бусад тохиолдолд эмнэлгийн байгууллагад зохион байгуулна.

9.3.Суралцагчийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ нь ерөнхий болон тусгай үзлэг, шинжилгээнээс бүрдэх бөгөөд тусгай үзлэг, шинжилгээний төрөл, хамрагдах нас, хүйсийн ангилал болон тусгай үзлэг, шинжилгээнд орох давтамж, хийх аргачлал, үйл ажиллагааг тайлагнах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.4.Эрүүл мэндийн ерөнхий үзлэг, шинжилгээнд бие бялдрын үнэлгээ, тулгуур эрхтний өөрчлөлт илрүүлэх, хараа, сонсгол, шүдний үзлэг, шинжилгээ багтах бөгөөд нэгээс арван хоёрдугаар ангийн нийт суралцагчдад жил бүр зохион байгуулна.

9.5.Энэ хуулийн 9.3, 9.4-т заасан үзлэг, шинжилгээнээс гадна дор дурдсан ангийн суралцагчдад дараах тусгай үзлэг, шинжилгээг заавал хийнэ:

9.5.1.нэгдүгээр ангийн суралцагчдад зүрхний цахилгаан бичлэг болон зүрх судасны тогтолцооны үзлэг, шинжилгээ;

9.5.2.тавдугаар ангийн суралцагчдад эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг үнэлэх илрүүлэх үзлэг, шинжилгээ;

9.5.3.аравдугаар ангийн суралцагчдад чихрийн шижингийн эрсдэлийг үнэлэх, сэтгэцийн эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, охидод цус багадалт илрүүлэх үзлэг, шинжилгээ.

9.6.Суралцагч нь сайн дурын үндсэн дээр Эрүүл мэндийн тухай хуулийн 8.5-д заасны дагуу эрт илрүүлэг, оношилгоонд хамрагдсан тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийг үндэслэн энэ хуулийн 9.1-т заасан суралцагчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдахгүй байж болно.

9.7.Сургууль нь энэ хуулийн 9.1-т заасан үзлэг, шинжилгээг зохион байгуулахаас нэг сарын өмнө суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шинжилгээний төрөл, хийх аргачлалын талаарх мэдээллийг бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

9.8.Суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10-т заасныг үндэслэн үзлэг, шинжилгээнд хамрагдахаас татгалзсан тохиолдолд тухайн үзлэг, шинжилгээ зохион байгуулагдахаас 7 хоногийн өмнө татгалзлаа бичгээр эсхүл цахимаар сургуульд мэдэгдэнэ.

9.9.Энэ хуулийн 9.1-т заасан үзлэг, шинжилгээг зохион байгуулагч нь сургуулийн эмч, эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн суралцагчийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний үр дүнг хүлээн авч, суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн санд тусгана.

9.10.Сургуулийн захирал нь үзлэг, шинжилгээнд хамрагдсан суралцагчдын эрүүл мэндийн нэгдсэн тайланд үндэслэн суралцагчийн эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөөг сум, дүүргийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй.

9.11.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тухайн шатны Засаг дарга нь сургуулийн захиралтай хамтран тухайн жилд хийгдсэн суралцагчийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээний нэгдсэн тайланг боловсруулж, энэ хуулийн 9.10-т заасан өмнөх хичээлийн жилийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн хамт тухайн хичээлийн жил дуусахаас 1 сарын өмнө аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт цахимаар эсхүл бичгээр хүргүүлнэ.

9.12.Энэ хуулийн 9.11-т заасан тайлангуудыг хүлээн авсан аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяалах нутаг дэвсгэрийн суралцагчдын эрүүл мэндийн нэгдсэн тайланг боловсруулж, эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудад тус тус хүргүүлнэ.

9.13.Боловсролын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд нь энэ хуулийн 9.12-т заасан тайланг нэгтгэн дүгнэж, суралцагчдын эрүүл мэндийн улсын хэмжээний үзүүлэлтийг цахим хуудсаараа олон нийтэд тайлагнана.

9.14.Сургуулийн захирал нь шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 9.10-т заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох эрүүл мэндийн байгууллагаас шууд дэмжлэг, тусламж авах эрхтэй. Эдгээр байгууллагууд нь шаардлагатай тусламжийг нэн даруй үзүүлж, суралцагчдын эрүүл мэндийг хамгаалахад хамтран ажиллах үүрэгтэй.

9.15.Энэ хуулийн 9.5-т заасан тусгай үзлэг, шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх бөгөөд тэдгээрээс бусад энэ хуулийн 9.1-т заасан үзлэг, шинжилгээний зардлыг суралцагчид ногдох хувьсах зардал болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагад олгож буй нэг иргэнээр тооцсон төсвөөс санхүүжүүлнэ.

10 дугаар зүйл.Суралцагчийн хувийн халдашгүй байдлыг хангах

10.1.Суралцагчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамаарах хувийн болон эмзэг мэдээллийг сургуулийн захирал, сургуулийн эмч, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.

10.2.Үзлэг, шинжилгээнд хамрагдсан суралцагчдын эрүүл мэндийн талаар статистик мэдээллийг боловсруулахад суралцагчийг тодорхойлох боломжгүй болгох арга хэмжээг авна.

11 дүгээр зүйл.Эмчилгээ болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ

11.1.Сургуулийн захирал нь энэ хуулийн 9.1-т заасан эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр өвчтэй эсвэл өвчлөх эрсдэлтэй гэж оношлогдсон суралцагчийг өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчлүүлэхэд шаардлагатай дараах арга хэмжээг нэн даруй авна:

11.1.1.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэн даруй мэдэгдэх;

11.1.2.шаардлагатай тохиолдолд суралцагчийг эрүүл мэндийн байгууллагад хүргэх;

11.1.3.шаардлагатай гэж үзсэн бусад.

11.2.Сургуулийн захирал нь суралцагчдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахтай холбогдох дараах арга хэмжээг авна:

11.2.1.суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш ажилтнуудад сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах;

11.2.2.шаардлагатай тохиолдолд тухайн суралцагчийг мэргэжлийн зөвлөгөө өгөх байгууллага болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагатай холбож өгөх;

11.2.3.суралцагчийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр зохион байгуулах.

11.3.Энэ хуулийн 11.1, 11.2-т заасан арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай зардлыг сургууль хариуцна.

11.4.Сургуулийн захирал нь энэ хуулийн 11.1, 11.2-т заасан арга хэмжээг зохион байгуулахад Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагад хүсэлт гаргах замаар хамтран ажиллана. Хуульд өөрөөр заагаагүй бол хүсэлт хүлээн авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага нь хамтран ажиллах хүсэлтээс татгалзах эрхгүй.

12 дугаар зүйл.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх

12.1.Сургуулийн орчинд халдварт өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, сургуульд суурилсан дархлаажуулалт, сургуулийн орчны халдваргүйжүүлэлт, ариутгалыг зохион байгуулах ажлыг сургуулийн захирал хариуцна.

12.2.Сургуулийн захирал нь хуульд заасан эрх бүхий этгээдийн шийдвэрээр эсхүл суралцагч болон сургуулийн ажилтнаас халдварт өвчин илэрсэн тохиолдолд бусад суралцагч болон сургуулийн ажилтанд халдахаас сэргийлэх арга хэмжээг нэн даруй зохион байгуулна.

12.3.Сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сургуулийн эмч нар нь халдварт өвчин илэрсэн суралцагч болон сургуулийн ажилтныг ялгаварлан гадуурхалтад өртөх болон бусад байдлаар эрх нь зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээг тэр даруйд авна.

12.4.Сургууль нь сургуулийн орчин, анги танхимын ариутгал, халдваргүйжүүлэлтийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө, суралцагчдын болон сургуулийн ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй арга хэлбэр, хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ.

12.5.Сургууль нь халдварт болон олон улсын хөл хориот өвчинтэй тэмцэх хүрээнд хуульд заасан эрх бүхий этгээдийн шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

13 дугаар зүйл.Сэтгэл зүйн зөвлөгөө

13.1.Сургуулийн сэтгэл зүйч нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т зааснаас гадна суралцагчийн насны ангилалд тохирсон сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлнэ.

13.2.Суралцагч нь ажлын цагаар биечлэн, утсаар, цахим хэлбэрээр сэтгэл зүйчээс зөвлөгөө авч болно.

13.3.Сэтгэл зүйч нь сэтгэл зүйн зөвлөгөөтэй холбогдох мэдээллийн нууцлалыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасны дагуу хадгална.

13.4.Сэтгэл зүйн зөвлөгөөний явцад суралцагч нь гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон байж болзошгүй нөхцөл байдал илэрвэл, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан арга хэмжээг нэн даруй авна.

13.5.Сургуулийн захирал нь суралцагчийн хувийн мэдээлэл задрахаас сэргийлсэн, шаардлага хангасан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө, орчныг бүрдүүлж өгөх үүрэгтэй.

13.6.Сэтгэл зүйч нь жил бүр асуумж болон ажиглалтын аргаар нийт суралцагчдаас сургуулийн орчинд тайван суралцахад тулгамдаж буй асуудал, дутагдлын талаар судалгаа авна.

13.7.Сэтгэл зүйч нь энэ хуулийн 13.6-д заасан судалгааны үр дүнг сургуулийн захиралд хүргүүлнэ.

13.8.Судалгааны үр дүнд үндэслэн сургуулийн захирал нь тухайн асуудлыг шийдвэрлэх бодлого, төлөвлөгөө боловсруулж нэг жилийн дотор асуудал, дутагдлыг бууруулах, арилгах үүрэгтэй бөгөөд тийнхүү бууруулсан, арилгасан тухай тайланг хичээлийн жил дуусахаас өмнө сум, дүүргийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагад тайлагнана.

13.9.Энэ хуулийн 13.6-д заасан судалгааны үр дүн 2 жил дараалан ижил байх тохиолдолд, тухайн сум, дүүргийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагаас тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зөвлөмж хүргүүлж, холбогдох арга хэмжээ авах үүрэгтэй.

13.10.Аливаа хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас энэ хуулийн 13.6-д заасан судалгааны үр дүнд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон тохиолдолд, сургуулийн сэтгэл зүйч энэ тухай сум, дүүргийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагад мэдэгдэнэ.

14 дүгээр зүйл.Суралцагчийн эрүүл мэндийн боловсрол

14.1.Сургуулийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлогын нэг бүрэлдэхүүн нь суралцагчийн эрүүл мэндийн боловсрол байна.

14.2.Эрүүл мэндийн боловсролыг тухайн чиглэлээр мэргэшсэн эрүүл мэндийн багш, эсхүл эрүүл мэндийн арга зүйч олгоно.

14.3.Сургууль бүр эрүүл мэндийн боловсрол олгох танхимтай байна.

14.4.Эрүүл мэндийн боловсролыг суралцагчийн нас, бие бялдрын хөгжилтэй уялдуулан эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан чиглэлийн дагуу бага, дунд, ахлах ангиудад тусгай хөтөлбөрөөр олгоно.

14.5.Төрийн болон орон нутгийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллагууд нь эрүүл өсөлт хөгжил, халдварт өвчин, халдварт бус өвчин, донтолт, осол гэмтэл, хүчирхийлэл, сэтгэц, бэлгийн болон нөхөн үржихүй, эрүүл ахуйн гар угаах, шүд угаах, хог хаягдлын менежмент, ариун цэврийн өрөөг зохистой ашиглах гэх мэт амьдрах ухааны ур чадваруудыг багтаасан сургалт, сурталчилгааны арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

14.6.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургуулийг суралцагчийн эрүүл мэндийн сургалтын танхим,цаг, ном, гарын авлага болон бусад шаардлагатай зүйлсээр хангана.

14.7.Сургууль нь амилуулах суурь тусламжийн сургалтад суралцагчдыг хамруулах ажлыг эрүүл мэндийн болон бусад холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

14.8.Амилуулах суурь тусламжийн сургалтад сургуулийн багш, ажилчид болон ахлах ангийн суралцагчид жил бүр хоёроо доошгүй удаа хамрагдана.

15 дугаар зүйл.Дархлаажуулалтын хяналт

15.1.Дархлаажуулалтын тухай хуулийн 10.3-т заасны дагуу Засгийн газраас баталсан үндэсний товллын заавал хийх дархлаажуулалтыг сургуульд суурилсан байдлаар зохион байгуулж болно.

15.2.Сургууль нь бага болон дунд сургуулийн суралцагчийг шинээр элсэн орох үед товллын дархлаажуулалтад бүрэн хамрагдсан эсэхийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс цахимаар эсхүл бичгээр лавлаж, уг мэдээллийг суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим санд оруулна.

15.3.Сургуулийн захирал нь товллын дархлаажуулалтад бүрэн хамрагдаагүй суралцагчид шаардлагатай вакциныг хийлгэх талаар удирдан зохион байгуулах үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд харъяа эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагаас дархлаажуулалтад дэмжлэг үзүүлэхийг хүсэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ СУРГУУЛИЙН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

16 дугаар зүйл.Сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө

16.1.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь 4 жил тутамд сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.

16.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн 16.1-т заасан төлөвлөгөөний биелэлтийг жил бүр дүгнэж, дараагийн хичээлийн жил эхлэхээс өмнө цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд тайлагнана.

16.3.Сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнахад шаардлагатай мэдээллийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан нь нэн даруй гаргаж өгөх үүрэгтэй.

16.4.Энэ хуулийн 16.1-т заасан төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнахад шаардлагатай санхүүгийн төлөвлөлтийг жил бүр улсын төсвөөс санхүүжүүлнэ.

16.5.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон тухайн шатны Засаг дарга нь энэ хуулийн 16.1-т заасан төлөвлөгөөнд нийцүүлэн сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх орон нутгийн төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжүүлэх үүрэгтэй.

16.6.Энэ хуулийн 16.5-т заасан сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх орон нутгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хичээлийн жил дуусахаас 1 сарын өмнө боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

16.7.Сургуулийн захирал нь энэ хуулийн 16.1, 16.5-д заасан төлөвлөгөөнд үндэслэн жил бүр сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургуулийн төлөвлөгөөг, өөрийн үнэлгээний тайлангийн хамт Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 24.1-т заасан сургуулийн зөвлөлтэй хамтран баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.

16.8.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сургуулийн өөрийн үнэлгээний тайлангийн аргачлалыг батална.

16.9.Сургуулийн захирал нь сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургуулийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг сургуулийн өөрийн үнэлгээний тайлангийн хамт сум, дүүргийн Засаг даргад хичээлийн жил дуусахаас 2 сарын өмнө хүргүүлнэ.

16.10.Сум, дүүргийн Засаг дарга нь сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай байгууламжийг байгуулах, аюул учруулах эрсдэлтэй байгууламжийг засварлаж, удирдан зохион байгуулах бөгөөд шаардагдах төсвийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

17 дугаар зүйл.Сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт

17.1.Сургуулийн захирал нь нийт суралцагчдад сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт жил бүр зохион байгуулж, түүний үр дүнг сум, дүүргийн боловсролын асуудал эрхэлсэн захиргааны байгууллагад тайлагнах үүрэгтэй.

17.2.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтын цаг, хөтөлбөр, ном, гарын авлага болон бусад шаардлагатай зүйлсээр хангах үүргийг хүлээнэ.

18 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сургалт

18.1.Сургууль нь суралцагчдад аюулт үзэгдэл, гамшгийн үед хүний амь нас аврах, гамшгийн нөхцөл байдлыг даван гарах анхан шатны чадварыг эзэмшүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулна.

18.2.Сургуулиас суралцагчдад аюулт үзэгдэл, гамшиг, ослын үед болон бусад тохиолдолд амь аврах, даван гарах чадварыг эзэмшүүлэх зорилгоор тухайлсан сургалтыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулна.

19 дүгээр зүйл.Дэмжлэг, тусламж үзүүлэх

19.1.Орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага болон сургуулийн захирал нь сургуулийн орчноос шалтгаалсан осол, гэмтлийн улмаас хохирсон суралцагч, тэдгээрийн гэр бүлийнхэнд сэтгэл зүйн тогтвортой байдал болон нийгэмд дасан зохицуулах зорилгоор зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйн эмчилгээ хийх зэрэг шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх үүрэгтэй.

20 дугаар зүйл.Сургуулийн орчинд тавигдах шаардлага

20.1.Сургуулийн барилга, байгууламж, эзэмшил газар нь холбогдох барилгын норм, стандартад заасан шаардлагыг хангасан байхаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

20.1.1.нарны тусгал, агаарын урсгал сайтай байх;

20.1.2.хүний биед сөргөөр нөлөөлөх агаар дуслын замаар дамжих бодис ашигладаг үйл ажиллагаанаас мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд заасан хэмжээнээс багагүй хэмжээнд зайтай байх;

20.1.3.орчин тойрондоо аюул учруулж болзошгүй барилга, байгууламжаас мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд заасан хэмжээнээс багагүй хэмжээнд зайтай байх;

20.1.4.байгалийн гамшгийн эрсдэл учирч болзошгүй газраас мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд заасан хэмжээнээс багагүй хэмжээнд зайтай байх;

20.1.5.сургуулийн барилга, байгууламжаас гарах хаалга нь замын хөдөлгөөний эрчим, нягтрал ихтэй бүст залгаа байж болохгүй;

20.1.6.сургуулийн барилга, байгууламж нь тогтмол дуу чимээний бохирдолтой бүсэд байж болохгүй;

20.1.7.сургуулийн барилга, байгууламж нь нарийн тоосжилт өндөртэй бүсэд байж болохгүй.

20.2.Барилга хот, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сургуулийн барилга, байгууламж баригдахаас өмнө болон дараа энэ зүйлийн 20.1-т заасан шаардлага болон сургуулийн барилга, байгууламжид холбогдох норм, стандарт, дүрэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэгтэй.

20.3.Энэ зүйлийн 20.1-т заасан шаардлага хангасан газрыг хайж олоход бүх шатны Засаг дарга тусламж үзүүлэх үүрэгтэй.

21 дүгээр зүйл.Сургуулийн эзэмшил газар дээрх аюулгүй байдлын шаардлага хангагдаагүйн улмаас үүсэх хариуцлага

21.1.Сургуулийн захирал нь сургуулийн барилга, байгууламж, биеийн тамирын талбай, сургуулийн эзэмшил газар дээрх аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

21.2.Сургуулийн барилга, байгууламж, биеийн тамирын талбай, сургуулийн эзэмшил газар дээрх аюулгүй байдалд холбогдох норм, стандарт, дүрмийг бүрэн хангаагүйн улмаас бусдын эрүүл мэнд, хөрөнгө, амь насанд учирсан хохирлыг Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасны дагуу сургууль хариуцан арилгах үүрэгтэй.

22 дугаар зүйл.Сургуулийн барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага хангагдаагүйн улмаас үүсэх хариуцлага

22.1.Сургуулийн барилга, байгууламжийн эрүүл ахуйн норм, стандартын хэрэгжилтийг сургуулийн захирал хариуцна.

22.2.Сургуулийн барилга, байгууламжийн эрүүл ахуйн норм, стандартыг хангаагүйн улмаас бусдын эрүүл мэнд, хөрөнгө, амь насанд учирсан хохирлыг Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасны дагуу сургууль хариуцан арилгах үүрэгтэй.

23 дугаар зүйл.Сургуулийн барилга, байгууламжийн засвар, үйлчилгээ

23.1.Сургуулийн барилга, байгууламжийн засвар, үйлчилгээний ажлын улмаас суралцагчийн эрүүл мэндэд учирсан хохирлын нөхөн төлбөрийг тэргүүн ээлжид сургууль хариуцна. Сургууль нь суралцагчийн эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгасны дараа буруутай этгээдээс нөхөн төлбөрт зарцуулсан мөнгөн төлбөрийг шаардах эрхтэй.

23.2.Сургуулийн барилга, байгууламжийн дотор засварын ажилд дотоод орчны агаарт ялгарах дэгдэмхий органик нэгдэл ашиглах тохиолдолд, тухайн засварын ажлыг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс 28 хоногийн өмнө гүйцэтгэсэн байна.

23.3.Сургуулийн барилга, байгууламжийн дотор засварын ажлыг энэ зүйлийн 23.2-т заасан хугацааны дотор гүйцэтгээгүй тохиолдолд, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулсны үндсэн дээр тухайн засвар хийсэн орчинд сургалтын үйл ажиллагаа явуулж болох эсэхийг шийдвэрлэнэ.

24 дүгээр зүйл.Сургуулийн орчны болон хүнсний эрүүл ахуй

24.1.Сургуулийн захирал нь сургуулийн орчны эрүүл ахуй болон хүнсний эрүүл ахуй нь холбогдох стандартыг хангаж буй эсэхтэй холбогдуулан жилд хоёроос доошгүй удаа хяналт, шалгалтыг зохион байгуулах бөгөөд үр дүнг тэмдэглэн сургуулийн зөвлөлд тайлагнана.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасан эрүүл ахуйн хяналт, шалгалтыг зохион байгуулахдаа сургуулийн зөвлөлийн эцэг эхийн төлөөллийг оролцуулна.

24.3.Энэ хуулийн 24.1-т заасан хяналт, шалгалтыг явуулахдаа эрүүл ахуй болон хүнсний эрүүл ахуй хариуцсан эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

24.4.Энэ хуулийн 24.1-т заасан хяналт, шалгалтын үр дүн нь сургуулийн орчны эрүүл ахуйн стандартад нийцээгүй бол, сургуулийн захирал нэн даруй шаардлагатай арга хэмжээ авч, сургуулийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулна.

24.5.Сургуулийн захирал нь энэ хуулийн 24.4-т заасан үр дүн болон авсан арга хэмжээний талаар сургуулийн зөвлөлд танилцуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

25 дугаар зүйл.Төрөөс бусад байгууллага, хувь хүнээс үзүүлэх дэмжлэг

25.1.Энэ хуульд заасан үйл ажиллагаа, арга хэмжээг явуулахад шаардлагатай зардлыг олон улсын, гадаадын болон дотоодын байгууллага, хувь хүний хандив тусламжаар санхүүжүүлж болно.

25.2.Санхүүжилтийн хэлбэр нь мөнгөн эсхүл бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ ханган нийлүүлэх хэлбэрээр байж болно.

26 дугаар зүйл.Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

26.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

27 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

27.1.Энэ хуулийг 2026 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Зургаадугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 6.32 дахь зүйл нэмсүгэй:

“6.32 дугаар зүйл.Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль зөрчих

1.Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль тогтоомж, стандартад заасан үүргээ биелүүлээгүй сургуулийн захирлыг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулахад хамтарч ажиллахаас үндэслэлгүйгээр татгалзсан албан тушаалтныг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.26 дэх заалтын "6.28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг" гэсний дараа "6.32 дугаар зүйл," гэж, 6.39 дэх заалтын "6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг," гэсний дараа "6.32 дугаар зүйл," гэж, 6.53 дах заалтын "Зөрчлийн тухай хуулийн" гэсний дараа "6.32," гэж, 6.54 дэх заалтын "6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг," гэсний дараа "6.32 дугаар зүйл," гэж, 6.58 дэх заалтын "6.28 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг," гэсний дараа "6.32 дугаар зүйл," гэж, 6.59 дэх заалтын "6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт," гэсний дараа "6.32 дугаар зүйл," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.11 дэх хэсэг нэмсүгэй:

“28.11.Суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийг хөтлөх, ашиглах зааврыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг